



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№61 /275/

2022.03.29

Цаг үе, үйл явдал

С.Төмөрхуяг: “ЭРЧЭЭ БИТГИЙ АЛДААРЫЙ”



БХЯ-ны харьяа “Соёмбо” редакцияас эрхлэн гаргадаг “Соёмбо мэдээ” өдөр тутмын цахим сонин уншигчдын хүртээл болоод нэг жилийг ардаа үдээд байна. Энэ хугацаанд

“Соёмбо мэдээ” цахим сонин 275 дахь дугаараар БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал болон Барилга инженерийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудад

өрнөж буй үйл явдлуудыг Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд төдийгүй энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй болон гадаадад суралцаж буй цэргийн алба хаагчдад цаг алдалгүй, шуурхай мэдээлснээс гадна иргэд, олон нийтэд эх оронч үзэл хүмүүжлийг олгож ажилласан байдаг.

Эх орны өнцөг булан бүрд үйл ажиллагаагаа явуулж байдаг Зэвсэгт хүчний нэгтгэл анги, салбарын мэдээ мэдээллийн нэг сувгаар хүлээн авахад тухайн ангийн Соёл хүмүүжлийн албаны офицеруудаас гадна орон тооны бус хэвлэл мэдээллийн ажилтнуудын үүрэг оролцоо их гэдгийг энд онцлох нь зүйн хэрэг юм.

Тийм ч учраас “Соёмбо” редакцын зүгээс өнгөрсөн нэг жилийн хугацаанд өөрийн нэгтгэл, анги, байгууллагад өрнөж буй үйл ажиллагааг цаг тухайд нь сурвалжлан мэдээ мэдээлэл бэлтгэн, “Соёмбо мэдээ” өдөр тутмын сонины цахим

шууданд шуурхай ирүүлж ажилласан алба хаагчдыг шалгаруулсан юм.

Энэ удаагийн “Соёмбо” редакцын гарын бэлэг, талархлын эзнээр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн Соёл хүмүүжлийн албаны дарга хошууч Д.Долгоржав шалгарсан юм. Тэрээр энэ хугацаанд 50 орчим мэдээг бэлтгэн цахим шууданд илгээж, өөрийн нэгтгэлийн үйл ажиллагааг сурталчилсан юм. “Соёмбо” редакцын дарга хурандаа С.Төмөрхуяг талархал, гарын бэлгийг хошууч Д.Долгоржав гардуулан өгөхдөө “Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах үүргийг бидэнтэй хамтран гүйцэтгэж байгаа Танд талархал илэрхийлэхийн ялдамд цаашдын ажилд нь амжилтыг ерөөе. Энэ эрчээ битгий алдаарай” гэж хүслээ.

Энэ арга хэмжээ цаашид үргэлжлэх бөгөөд өөрийн нэгтгэл анги байгууллагын үйл ажиллагааг идэвхтэй сурталчилсан алба хаагчдыг жил бүр тодруулах юм.

ХУРАНДАА Б.ЭНХЗОРГОЛ ДОКТОРЫН ЗЭРГЭЭ ХАМГААЛАВ



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Б.Энхзоргол “Нийслэл хотыг агаарын довтолгооноос хамгаалах боломжийн судалгаа” сэдвээр Цэрэг, батлан хамгаалах мэргэжлээр Цэргийн ухааны (Ph.D) доктор-ын

зэргийг хамгааллаа. Докторын зэргийн дипломыг УБХИС-ийн эрдмийн зөвлөлийн хурлын үеэр УБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан гардуулан өгсөн юм. Тэрээр шинэхэн докторт хандан Баяр хүргэж, ажилд улам их амжилт хүссэн юм.

“ХИАГТЫГ ЧӨЛӨӨЛСӨН НЬ” БОЛОВСРОЛЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



“Монгол цэргийн өдөр” Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны 101 жилийн ойд зориулан Монгол цэргийн музейгээс хэрэгжүүлсэн “Хиагтыг чөлөөлсөн нь” боловсролын ажил энэ сарын 27-ны өдөр Монгол цэргийн музейд боллоо.

Тус боловсрол танин мэдэхүйн ажил нь түүхэн уламжлалаа нандигнан өвлүүлэх, эв нэгдлийг бэхжүүлэх хүүхдэд залууст цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилготой бөгөөд Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 119 дүгээр сургуулийн 11-2 ангийн 17 хүүхэд хамрагдлаа.

Үйл ажиллагааны хүрээнд “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэж эхэлсэн тухай болон Ардын журамт цэргийн зохион байгуулалт бүрэлдэхүүний талаар, 1921 оны Үндэсний эрх чөлөөны хувьсгалын анхны ялалт болох “Шивээ хиагт”-ын тулалдааны талаар мэдээлэл өгч хэлэлцүүлэг өрнүүлэн тухайн үеийн улс орны нөхцөл байдал, цэргийн зохион байгуулалтын талаар энэ үетэй холбогдох түүхэн үзмэр эд өлөг баримт материалууд дээр тулгуурлан ярилцлаа.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 2	☁️ -11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 19

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,950.00	2,980.0
EUR 🇪🇺	3,400.0	3,450.0
CNY 🇨🇳	492.00	497.00
RUB 🇷🇺	33.00	34.20
JPY 🇯🇵	26.70	28.00
KRW 🇰🇷	2.52	2.55

ЗУРХАЙ

2022.03.29 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 27/

ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.37-19.17

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал: Уул

Энэ өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2,272,363 /69.8%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,174,463 /66.8%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

1,031,968 31,7%
114,380 /3,5%/

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
8435 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
4

ЭДГЭРСЭН
8310

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 483,779,616

Эдгэрсэн

Нийт: 417,958,721

Нас барсан

Нийт: 6,152,011



Цахим шууданд

ЗАСМАЛ ЗАМЫН ДУГУЙН ТЭМЦЭЭН 31 ЖИЛИЙН ДАРАА БОЛОВ



Засмал замын дугуйн 2022 оны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн Тажикстан улсын нийслэл Душанбе хотод 3 дугаар сарын 25-29 ний хооронд зохион байгуулагдаж байна. Тус засмал замын дугуйн ази тивийн аварга шалгаруулах тэмцээн 31 жилийн дараа болж байгаа аж. Уг тэмцээнд Багийн

цуваа гараатай 24км уралдаанд Монгол улсын баг тамирчид мөнгөн медаль хүртлээ. Багийн бүрэлдэхүүнд БХЯ-ны харьяа "Алдар" спорт хорооны тамирчин ОУХМ С.Жамбалжамц, ОУХМ Б.Тэгшбаяр, "Тийн огги" клубийн тамирчин ОУХМ Б.Марал-Эрдэнэ, ОУХМ Э.Билүүнжаргал нарын

бүрэлдэхүүнтэй оролцлоо. Мөн насанд хүрэгчдийн эмэгтэйчүүдийн ганцаарчилсан цуваа гараатай 24км уралдаанд Ази тивийн шилдэг 11 орны тамирчид өрсөлдсөнөөс, БХЯ-ны харьяа Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны тамирчин ОУХМ Ц.Солонго хүрэл медалийн эзэн боллоо.

ЦЭРГИЙН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАВ



байцаагч, эрүүгийн мөрдөн байцаах тасгийн эрүүгийн мөрдөгч, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн байцаагчид замын хөдөлгөөний дүрэм, жолооч зорчигчийн үүрэг, явган зорчигчийн үүрэг, цахим гэмт хэрэг цахим мөрийтэй тоглоомын тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зүйл заалт зэрэг сэдвүүдээр бие бүрэлдэхүүнд яриа таниулга хийлээ.

Ахмад Б.ГАНЧУЛУУН

Зэвсэгт хүчний 353 дугаар анги

Налайх цэргийн хүрээний цэргийн цагдаагийн тасгийн бүрэлдэхүүн тус ангид хүрэлцэн ирж өөрсдийн албаны онцлог гүйцэтгэх үүрэг, Зэвсэгт хүчний анги байгууллагуудын нийт цэргийн алба хаагчдын гаргаж буй зөрчил, дутагдлын талаар яриа хийж, бие бүрэлдэхүүний тавьсан асуултад тодорхой хариулт өглөө.

Энэ үеэр мөн Налайх дүүргийн замын цагдаагийн



ЭНЭ УДААГИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦАГААР

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Алба хаагчдын сэтгэл зүйд дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээх, сэтгэл зүйн стресс бухимдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, стрессийн түвшнийг тодорхойлох зорилгоор нийт бие бүрэлдэхүүнээс симфони хөгжмийн аялгуунд "Гар зураг" зуруулах аргаар сорил судалгаа авсан бөгөөд энэ үеэр цэргийн гал тогооны бүрэлдэхүүн халуун аарцаар үйлчилж гар нийлэмжтэй хамтын ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

Мөн тус арга хэмжээний дараа энэ сарын онцлох ахлагчаар Барилга

угсралт засварын ротын засал чимэглэлчин, дэд ахлагч Ч.Энхзаяаг онцолсон бөгөөд түүнд хандаж алба хаагчид чин сэтгэлийн үгээ илэрхийлж түүний цаашдын ажил, албанд өндөр амжилт хүссэн юм.

Дэд ахлагч Ч.Энхзаяа нь албан үүргээ гүйцэтгэхийн хажуугаар тогтмол ном, сонин уншиж өөрийн мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж ажилладаг ба түүний энэ сард шинэхэн уншиж эхлүүлсэн ном нь Г.Золзаяагийн зохиол "Мухулай" номын талаар товч танилцууллаа. Түүнчлэн алба хаагчид бие

биедээ "Талархлын захиа" бичиж хүргүүлэв.

Бие бүрэлдэхүүний нийгэм хууль эрх зүй, албаны хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Төрийн болон албаны хадгалалт, хамгаалалт" сэдвээр нууцын дарга, архивын эрхлэгч, ахлагч М.Мөнгөнзул "Мэдээллийн аюулгүй байдал болон холбооны гар утсыг ашиглах журам" сэдвээр Холбооны техник хэрэгслийн инженер Б.Мөнхцэцэг даргатай холбооны алба тус тус лекц бэлтгэн ажиллаа.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

